



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2022 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 06 дугаар сарын 30-ний өдрийн 19 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

ХИХ.5."ХЭЛЭЛЦСЭН нь: "Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлын түрээсийн орлогын тухайб

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 455 тогтоолоор "Буянт-Ухаа" нисэх буудлыг нөөц нисэх буудал болгосон, арилжааны нислэг үйлдэгдэхгүй болсон, 2020 оноос дэлхий нийтийг хамарсан цар тахал дэгдэж, иргэний нисэхийн салбар зогсонги байдалд хүрсэн зэргээс шалтгаалан "Буянт-Ухаа" олон улсын нисэх буудал үйл ажиллагаа доголдож, зардлаа төлж чадахгүй, алдагдалтай ажиллах хэмжээнд хүрч, санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдалд ороод байна.

Мөн тус байгууллага нь Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2022 оны А/115 дугаар тушаалаар Буянт-Ухаа олон улсын нисэх буудлын үйл ажиллагааны журамд өөрчлөлт оруулж нисэх буудлын байр талбайг иргэн, хуулийн этгээдэд түрээсэлж орлого бүрдүүлэх үндсэн чиг үүрэгтэй болсон тул Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 50 дугаар тогтоолын 2.1-т "Төрийн өмчит хуулийн этгээдээс тухайн хуулийн этгээдийн технологийн болон үндсэн үйл ажиллагаанаас бусад зориулалтаар төрийн өмчийн эд хөрөнгийг иргэн хуулийн этгээдэд түрээслүүлэх талаар ирүүлсэн саналыг хянан үзэж зөвшөөрөл өгч байх" гэж заасны дагуу үндсэн үйл ажиллагааны орлого болох түрээсийн орлогыг 1 жилийн хугацаанд байгууллагад нь үлдээх нь зүйтэй гэж үзэв" гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР